



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

Багш хөгжлийн төв, 11 баг, 6-р хороо,
Дархан сум, Дархан-Уул аймаг 45059
Утас/факс: (976) 7037-0011
Цахим шуудан: dca@da.moc.gov.mn

2024.05.31 № 01/176
танай _____-ны № _____-т

СОЁЛЫН ЯАМНЫ СОЁЛЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА Д.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

Тус газраас “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээний хүрээнд харьяа Соёлын байгууллагуудын зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг нэгтгэн хүргүүлж байна.

Хавсралт...²¹...хуудастай.

ДАРГА



Х.СОЁЛ ЭРДЭНЭ

4524010223



مركز البحث والدراسات
العلمية - القدس

البريد الإلكتروني: dca@da.moc.gov.mn
 رقم الهاتف: 7037-0011 (976) 044
 رقم الفاكس: 45059
 العنوان: القدس 11، رفح من القدس، فلسطين

التوقيع:  / 

الرقم: _____ - الترخيص: _____ في القدس

المراسلة: القدس، القدس

رقم الترخيص: 1922050017

مركز البحث والدراسات العلمية والدراسات
 البحثية في القدس، القدس، القدس
 والدراسات العلمية والدراسات
 البحثية في القدس، القدس، القدس
 القدس، القدس، القدس



مركز البحث والدراسات العلمية
 القدس - القدس

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

“ИЛҮҮ ИХ УНШЪЯ” УРИАН ДОР “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2024” ХАВРЫН БАЯРЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2024.05.31

Дархан-Уул аймаг

НЭГ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

Зорилго: “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

“Номын баяр-2024” арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын санаачилгаар “Илүү их уншъя” уриан дор 2024 оны 05 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн өнгө төрх, нэгдмэл агуулгатайгаар явагдлаа.

Дархан-Уул аймагт хаврын номын баярыг 5 дугаар сарын 18-наас 5 дугаар сарын 30-ны хугацаанд нийт 13 өдөр олон талт үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн. Аймгийн Соёл, урлагийн газар, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Шарын гол, Орхон, Хонгор сумын Соёлын төвүүд, Залуучууд театр, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд болон ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын номын сангууд, ном хэвлэн нийтлэгчидтэй хамтран нийт **53 арга хэмжээг 63 удаа** зохион байгуулж, **13,965** хүнийг хамруулсан.

Аймгийн Соёл, урлагийн газар нь Хаврын номын баярын нээлт болон бусад үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг хянаж батлан, аливаа үйл ажиллагаануудыг зохион байгуулахад аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллав. Төлөвлөгөөний дагуу явцын тайланг 2024 оны 05 дугаар сарын 17, 21-ний өдрүүдэд 2 удаа нэгтгэн ЗГХА- СУГ-т хүргүүлсэн. Нэгдсэн дэлгэрэнгүй тайланг 2024 оны 05 дугаар сарын 31-ний дотор хүргүүлэхээр харьяа байгууллагуудаас үйл ажиллагааны тайланг хүлээн авч нэгтгэн хяналтад авлаа.

Нээлтийн үйл ажиллагаа:

2024 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 11:00 цагт “Найрамдал талбай”-д “Номын баяр-2024” арга хэмжээний нээлтийг албан ёсоор зохион байгуулав.

Аймгийн Соёл, урлагийн газар, тус газрын харьяа соёлын байгууллагууд, СӨБ-ын 5 цэцэрлэгийн 210 багш, хүүхэд, ЕБ-ын 12 сургуулийн 1425 багш, сурагч, тэдгээрийн эцэг эхийн төлөөлөл, Сумдын соёлын төвүүд, Ахмадын Хороо болон Дархан сумын 8 дугаар багийн ахмадын зөвлөл, Ахмадын Хөгжлийн Төв, тусгай хэрэгцээт залуусын “Урам” төв, Номын худалдаа эрхлэгч 5 байгууллага, үнэт ховор номын үзэсгэлэн, номын худалдаа, ном солилцоогоор оролцов.

Номын баярын нээлтэд нийт **28** байгууллагын **1565** хүн оролцож **300** гаруй иргэд номын баярыг үзэж сонирхохоор хүрэлцэн ирсэн юм.



Зураг 1: “Номын баяр”-ын нээлтэд аймгийн Соёл, урлагийн газар, Дархан сумын ЗДТГ, Залуучууд театр, Төв номын сан, Хүүхдийн номын ордны удирдлагууд оролцов.

“Номын сайн нөхөр” Улсын уралдаан:

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2024”-ийн хүрээнд Монгол Улсын Их хурлын дарга Гомбожавын Занданшатарын санаачилсан **“Номын сайн нөхөр”** улсын уралдаанд Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар нь аймгийн Төв номын сан, Хүүхдийн Номын Ордноос “Шилдэг уншигч-анги хамт олон”, “Шилдэг номын сан”, “Шилдэг уншигч”-ийн материалуудыг хүлээн авч хянан, шалгуур хангасан нийт 6 материалыг ЗГХА- Соёл, урлагийн газарт хүргүүлж ажилласан.

Уралдаанд Дархан-Уул аймгийн "Од" цогцолбор сургуулийн 5-10 ангийн хамт олон “Тэргүүний шилдэг уншигч- анги хамт олон”-оор шалгарч 2024 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо "35 дахь Номын баяр"-ын тайзнаа УИХ-ын дарга Г.Занданшатараас шагналаа гардан авсан. Дээрх анги хамт олныг Улаанбаатар хот руу очиж шагналаа авахад нь аймгийн Засаг даргаас хүүхдийн автобус, жолоочийн асуудлыг шийдвэрлэж, аймгийн Соёл, урлагийн газраас шатахууны дэмжлэг үзүүлж ажиллав. Мөн ЗГХА-СУГ-аас уншигч хүүхдүүдийг Чингис хааны музей үзүүллээ.



Зураг 2: Тэргүүний шилдэг уншигч- анги хамт олон” шагналын эзэд.



Зураг 3: Тэргүүний шилдэг уншигч- анги хамт олон” шагналын эзэд.

Тус аймагт зохион байгуулсан Хаврын номын баярын нээлтийн үеэр 2024 оны шилдэг уншигч-анги хамт олон- 9, шилдэг номын санч-1, шилдэг уншигч- 2, Дархан сумын 10 дугаар багийн иргэн шилдэг уншигч-1 нийт 11 уншигчийг шалгаруулж шагналыг аймгийн Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ гардуулсан.



Зураг 4: Тэргүүний шилдэг уншигч- анги хамт олон”-д шагнал гардуулж байгаа нь

ХОЁР. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН

“Номын баяр-2024” арга хэмжээний нээлтэд 3000 гаруй иргэдийг хамруулж нийт 26 арга хэмжээг 59 удаа зохион байгуулж 11,347 хүнийг хамруулсан. **Үүнд:**

1. Номын баярын нээлтийн үйл ажиллагаанд:

-Карнавал жагсаал: Номын баярын нээлтээр Дархан-Уул аймгийн ЕБС, СӨББ-ын 1635 багш, сурагчид, эцэг эхийн төлөөлөлүүд баярын жагсаалаар идэвхтэй оролцсон.



Зураг 5: Уншигч хүүхдүүд нээлтийн үйл ажиллагаанд анги хамт олноо сурталчлав

-Урлагийн тоглолт: Номын баярын нээлтэд Залуучууд театрын уран бүтээлчид, ЕБС, СӨББ-ын 12 байгууллагын 28 шилдэг уншигч хүүхдүүд, анги хамт олноороо оролцож Монголын сор болсон зохиолчдын шүлэг, найраглалыг уншиж, дуу, бүжиг, дүрийн тоглолтуудыг номын баярт хуран цугларсан ард иргэд, эцэг эхийн төлөөлөл, хүүхэд багачуудад толилууллаа.



Зураг 6: Урлагийн тоглолтод 400 гаруй хүүхэд оролцсон.

-Шагнал, урамшуулал: Хүүхэд, өсвөр үеийг номтой нөхөрлүүлэх зорилгоор "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн"-г шалгаруулан алдаршуулдаг бөгөөд 2024 оны Хаврын номын баярын "Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн"-ий болзол хангасан сурагч, анги хамт олныг алдаршуулав.

Тэргүүний уншигч:

- 10 дугаар багийн иргэн, уншигч Жаргалсайханы Энхзул
- ОИЦ сургуулийн 3-3 дугаар ангийн сурагч Энхтөрийн Төрмандах
- 18 сургуулийн 5а ангийн сурагч Бямбажавын Элбэгдаваа

Тэргүүний уншигч анги хамт олноор:

- ✓ Б.Янжинлхам багштай Шинэ- Алхам сургуулийн 5А анги
- ✓ Д.Цэндбазар багштай 1 дүгээр сургуулийн 5в анги
- ✓ Д.Энхтунгалаг багштай Од цогцолбор сургуулийн 5-6-р анги

Тэргүүний уншигч номын санч:

- ✓ Ахмадын хөгжлийн төвийн номын санч А.Сувд-Эрдэнэ
- ✓ 10-р багийн иргэн, уншигч Ч.Нарантуяа



Зураг 7: Номын сангийн захирал Б.Цэцэгсүрэн Тэргүүний шилдэг уншигч- анги хамт олон"- д шагнал гардуулж байгаа нь

-Бүтээлийн үзэсгэлэн: Сургуулийн өмнөх боловсролын бяцхан хүүхдүүдийн багш, эцэг эхчүүдийн "Үлгэрээс үлгэрлэе" бүтээл, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уншсан номын тэмдэглэлийн үзэсгэлэнд нийт 8 байгууллагын 102 хүн бүтээлээ дэлгэж оролцлоо.



Зураг 8: Бүтээлийн үзэсгэлэн

-Хуучин номын худалдаа, ном солилцоо, хандив: 35 дахь “Номын баяр-2024”-ийн хүрээнд хувийн хэвшлийн номын худалдаа эрхлэгч 5 байгууллагын 6 иргэн 320 гаруй боть, номоор номын худалдаа явуулж 1.0 сая гаруй төгрөгийн 170 гаруй боть номны борлуулалт хийж ажилласан байна. **Хандив:** Аймгийн ахмадын хороо 65 боть, Од цогцолбор сургуулийн 3-2, 4-5 ангийн хамт олон 29 боть, 8, Дархан сумын 12 дугаар багийн ахмадын зөвлөл 44 боть ном, **нийт 1 500 000** төгрөгийн **146** нэр төрлийн 146 боть номыг аймгийн Төв номын санд хандивласан байна.



Зураг 9: Номын худалдаагаар 1.0 сая гаруй төгрөгийн 170 гаруй боть ном борлуулав

-УБТЗ-ын аялалын хөтөлбөр: Номын сангийн “Хөгжөөнт тоглоом” боловсролын хөтөлбөрт Нийслэлийн ЕБ сургуулийн 4-1 ангийн 22 сурагч, ахлах ангийн 52 сурагч нийт 74 хүүхэд хамрагдсан.



Зураг 10: Аялагч хүүхдүүд номын сангийн хөтөлбөрт хамрагдаж буй нь.

2. Номын баярын үйл ажиллагааг Төв номын сан 2024.05.18-30-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Үүнд:

-Эрдэм шинжилгээний хурал: “Үндэсний бичиг соёл номын өдрүүд -2024”-ийн арга хэмжээний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр аймгийн Монгол хэл бичиг, уран зохиолын багш нарын дунд “Хос бичигтэн-2025” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 50 гаруй багш, номын санчид оролцсон.



Зураг 11: Эрдэм шинжилгээний хурлын явц

-Дүрийн тоглолттой уншигчдын бага хурал: “Лагшмын соёрхол” Энэтхэг ардын үлгэрийн номоор “Дүрийн тоглолттой уншигчдын бага хурлыг 9 дүгээр сургуулийн 6г ангийн сурагчид зохион байгуулж, 50 гаруй багш, сурагчид, эцэг эх оролцсон. Хуралд “Зөв хүүхэд гэж хэн бэ?” сэдвээр багш Э.Уянга, “Дүрийн онцлогийг илэрхийлэх нь” сэдвээр сурагч Б.Эгшиглэн, Г.Намуунаа, Э.Энхзаяа, Д.Нармандах, Н.Цэлмэг нар илтгэл тавьж харилцан ярилцаж санал бодлоо солилцлоо.



Зураг 12: Уншигчдын бага хурлын явц

-Бүтээлч болон Чанга уншлага:

ЕБС, СӨББ-ын хүүхдүүдэд “Үлгэрээс үлгэрлэе”, “Мэргэн хүү Өгөдэй” сэдвээр бүтээлч болон чанга уншлагыг 25 удаа зохион байгуулж 958 хүүхдийг хамруулсан. Уншилтаар сурагчдын уншсан номын тухай тэмдэглэл хөтлүүлж үлгэрийн ач тус, сайн, муугийн ялгааг ярилцав.



Зураг 13: Соёл олон нийтийн ажлуудын явцаас

-“Сургалт, хэлэлцүүлэг, уулзалт”: “Номын баяр-2024”-ийн хүрээнд зохион байгуулсан “1:3:5” Зочинтой өдөр” уулзалт, ярилцлагад аймгийн Прокурорын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд оролцож “Зөрчлийн хууль тогтоомж”, “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголт, Байгаль хамгаалал” сэдвээр тус тус мэдээлэл хийсэн. Тус өдрийн арга хэмжээнд 24 хүн хамрагдав.



Зураг 14: “1:3:5” Зочинтой өдөр” уулзалтын явцаас

-Зохиолч уншигчдын уулзалт: Дархан нутгийн зохиолчдын 2014-2024 онд бүтээн турвисан уран бүтээлүүдийг уншигчдад түгээх, сурталчлах зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Төв номын санд “Зохиолч, уншигчдын уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад ЕБ-ын 15 дугаар сургуулийн ахлах ангийн 121 сурагчийг хамруулж илтгэгчээр МЗЭ-ийн гишүүн, МЗЭ-ийн болон “Утга зохиолын төлөө” шагналт, зохиолч яруу найрагч Н.Төмөртоогоо, Д.Мөнххишиг, шог зураач Д.Мянганзам, ая зохиогч Ц.Ичинхорлоо, Ц.Ганбаатар нар оролцсон.



Зураг 15: “Зохиолч, уншигчдын уулзалт”-ын явцаас

-“Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх” сэдэвт хэлэлцүүлэг: Дархан-Уул аймгийн Төв номын сан нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх” сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Дархан сумын ЗДТГ, Дархан сумын ИТХурал, Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Ахмадын хөгжлийн төв, Хүний эрхийн Үндэсний Комиссын Дархан-Уул


аймаг дахь салбар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг, эхийн холбоо болон бусад холбоод, иргэдийн төлөөлөл 24 хүн оролцов.

Хэлэлцүүлгээр Номын сангийн хүртээмж нь хэрэглэгчдэд номын сангийн үйлчилгээг ялгаваргүйгээр тэгш хүргэх, уншигчдад тохирсон дэд бүтэц, орчин нөхцөлийг бүрдүүлэх, номын баяжилт, техник хэрэгслээр хангаж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар ярилцав.



Зураг 16: Хэлэлцүүлгийн явцаас

-Видео, контент, уралдаан: "Номонд дурлагсад" цуврал богино хэмжээний нэвтрүүлгийг 2 удаа зохион байгуулж 4320 хүнд хүргэсэн. Нэвтрүүлэгт "Чихтэй шувууны садан" номын нөхөд ахмад шүүгч, Л.Амарсанаа, хэл шинжлэлийн ухааны магистр, бичгийн их хүмүүн Ж.Эрхэмсайхан нар оролцсон. "Бидний номын сан" видео бичлэгийн уралдааныг ЕБС-ийн сурагч, иргэд, уншигчдын дунд зохион байгуулсан.



Зураг 17: "Номонд дурлагсад" цуврал богино хэмжээний нэвтрүүлэг

-“Ном” уран илтгэлийн уралдаан: Аймгийн Төв номын сангаас бага насны хүүхдийн дунд “НОМ” илтгэлийн уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд нийт 28 СӨБ болон ЕБС-ийн нийт 38 хүүхэд багачууд амжилттай оролцлоо.



Зураг 18: “Ном” уран илтгэлийн уралдааны явцаас

ГУРАВ: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх хүрээнд хүрээнд тус ордноос **11** арга хэмжээг зохион байгуулж **1826** хүнийг хамруулж ажиллалаа.

1. Хаврын номын баярын нээлтийг аймгийн Төв номын сантай хамтран зохион байгуулж тус ордны 17 албан хаагч, байнга хамтран ажилладаг ЕБ-ын 6 сургуулийн 124 сурагч, багш, эцэг эхийн төлөөлөл, СӨББ-ын 8 цэцэрлэгийн 147 хүүхэд, багш, эцэг эх зэрэг нийт 288 хүн оролцлоо. **Үүнд:**

-Бүтээлийн үзэсгэлэн: Бийрийн бичгийн уралдааны шагналт байранд орсон сурагчдын бүтээл, албан хаагчдын үндэсний бичгээр хичээнгүй бичгийн бүтээл, Хос бичгээр хэвлэгдсэн ном, судрын үзэсгэлэн зэрэг 3 нэр төрлийн 38 бүтээлийн үзэсгэлэнг 368 хүнд хүргэсэн.



Зураг 19: Бүтээлийн үзэсгэлэн

“Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан Цайхун сургуулийн 2^а, 6^а ангийн 20 гаруй, Од сургуулийн 3^д ангийн 8 сурагч, 9-р сургуулийн 5^б ангийн 12 сурагч, ОИЦ сургуулийн 5^д ангийн 16 сурагч, 16-р сургуулийн 5^б ангийн 15 сурагчдын бүтээлийн 100 гаруй үзэсгэлэнг гаргав. Мөн шагнал гардуулах үйл ажиллагаанд 102 сурагч оролцлоо.



Зураг 20: Хүүхдийн номын ордны уншигч хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн

-Боловсролын хөтөлбөр: Нээлтэд тус ордны боловсролын хөтөлбөр “Өв соёлоо мэдь”, “Уламжлалт тоглоом наадгай”, “Монгол гэр”-загвар гэр барих зэрэг нийт 3 боловсролын хөтөлбөрт 152 хүнийг хамруулсан. Энэ үеэр 37 иргэн, уншигчдад номын сангийн картыг хөнгөлөлттэй үнээр нээж үйлчилсэн.



Зураг 21: Хүүхдийн номын ордны уншигч хүүхдүүдэд шагнал гардуулж буй нь

-Шагнал, урамшуулал: 2024 оны “Тэргүүний шилдэг уншигч-анги хамт олон”-3 ангийг урин алдаршуулсан.



-Номын үзэсгэлэн, номын худалдаа: Сан хөмрөг дэх номоо олон нийтэд хүргэх, номын эргэлтийг сайжруулах зорилгоор сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тус баярын нээлтэд зориулан 42 боть номоор дэлгэж 328 хүнийг хамруулан 3 иргэнийг номын худалдаанд урьж оролцуулсан.



Зураг 22: Хүүхдийн номын ордны Номын үзэсгэлэн, номын худалдаа

2. Хүүхдийн номын ордон нь 2024.05.18-30-ны өдрийг хүртэлх хугацаанд дараах ажлуудыг өөрийн байранд болон бусад газруудад зохион байгуулсан. Үүнд:

-Сургалт: “Номын баяр-2024” -ийн хүрээнд “Од” сургуулийн сурагч, бийрийн бичгийн сурагч багш Д.Номинзул Хүүхдийн номын ордны 12 албан хаагчдад “Бийрэн бичиг”-ийн сургалтыг оров.



Зураг 23: Хүүхдийн номын ордны “Бийрэн бичиг”-ийн сургалт

-Уншлага, уралдаан: Тус ордны албан хаагчид “Номын баяр”-ыг тэмдэглэх хүрээнд өглөө бүр “Хүмүн бичиг” сонины уншлага хийж, 16 албан хаагчдын дунд Үндэсний бичгийн “Түргэн уншлага”-ын уралдааныг зохион байгуулж 1-2 байр эзлүүлэн шагнаан урамшуулав.



Зураг 24: “Түргэн уншлага”-ын уралдааны үеэр...

Дархан-Уул аймгийн 3, 7 дугаар цэцэрлэгийн дунд, ахлах, бэлтгэл бүлгийн 303 хүүхэд багачуудад Т.Жамъянсүрэнгийн “Мэлхий суралцсан нь”, “Хормогчин үлгэр”, “Монгол ардын үлгэр”, “Ухаант туулай” үлгэрээр “**Чанга уншлага**” хийж харилцан яриа өрнүүлсэн. Мөн багачуудын нас сэтгэхүйд тохирсон 80 гаруй зурагт номыг сонирхуулж танилцуулав.



Зураг 25: “Чанга уншлага” -ын үеэр...

Монгол бичгийн мэдлэг чадварыг ахиулах, бийрийн бичлэгийг сурах хүсэл сонирхолыг нэмэгдүүлэх, бийрийн эрдмийн гайхамшгийг олон нийтэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх зорилгоор ЕБС-ийн 6-9, 10-12 дугаар ангийн сурагчдын дунд “Бийрийн бичиг”-ийн уралдааныг 50 гаруй сурагчдын дунд зохион байгуулсан.



Зураг 26: “Бийрийн бичиг”-ийн уралдааны явц...

“Номтой өдөр” арга хэмжээ: “Үндэсний бичиг үсэг, номын баяр”-ыг тохиолдуулан “Элит-22” сургуультай хамтран “Номтой өдөр” -ийг 2 удаа зохион байгуулж 120 хүнийг хамруулсан. Энэ үеэр шинэ номын танилцуулга, ном уншлага, хөнгөлөлттэй үнээр уншигчийн карт нээх, хөгжөөнт танин мэдэхүйн “Хэн хамгийн сайн үг бүтээх вэ? тэмцээн, Чанга уншлага, “Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх” зэргийг зохион байгуулсан.



Зураг 27: "Номтой өдөр" арга хэмжээний үеэр...

-Аялалын хөтөлбөр: "Номын баяр-2024"-ийн хүрээнд Од сургуулийн 5-1 ангийн 12 сурагчдын дунд "Номтой аялал"-ыг "Миний монгол" цэцэрлэгт хүрээлэнд 2024 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан.

Мөн тус ордны номын сангийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор 7 дугаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 35 хүүхдийн дунд "Танилцах аялал"-ыг зохион байгуулж нас сэтгэхүйн онцлогт тохирсон зурагт болон танин мэдэхүйн номоор үйлчилсэн.




Зураг 28: Танилцах аяллын үеэр...

ДӨРӨВ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ

Шарын гол сумын Соёлын төв нь "Илүү их уншъя" уриан дор "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулж сумын иргэд, уншигч, хүүхэд багачуудын дунд нийт 8 арга хэмжээнд 524 хүнийг хамруулж ажиллалаа. Дархан суманд болсон Хаврын номын баярын нэгдсэн үйл ажиллагаанд ЕБС-ийн сурагчдын урлагийн тоглолт, бүтээл үзэсгэлэнгээр оролцсон. Үүнд:

1. Номын баярын нээлтийн үйл ажиллагаанд:

"Номын баяр-2024" нээлтийн үйл ажиллагаанд тус сумын ЕБС-ийн 2в ангийн 13 сурагч урлагийн тоглолт, сурагчийн бүтээлийн бичвэр, бийрэн бичлэгийн болон бусад бүтээлийн үзэсгэлэнгээр оролцсон. /2024.05.18/



Зураг 29: Шарын гол сумын уншигчид...

2. Номын баярын үйл ажиллагааг Төв номын сан 2024.05.18-30-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Үүнд:

-“Бүтээлч болон чанга уншлага:

Шарын гол сумын 2,14,19 дүгээр цэцэрлэгийн бэлтгэл, ахлах бүлгийн 106 хүүхдийн дунд “Үнэг тогоруу хоёр” сэдвээр “Чанга уншлага”-ыг зохион байгуулсан. Уншлагын үеэр хүүхдүүдэд ном унших нь утас, цахим хэрэглээнээс илүү ач тустай гэдгийг ойлгуулах талаар ярилцлаа. /2024.05.20/



Зураг 30: Шарын гол -Чанга уншлага

"Номын баяр-2024"-ийн хүрээнд ЕБС-ийн 62 багш, ДШГХК-52 ажилтан, Тулга сувилал-16 эмч, сувилагч, Гал түймэр унтраах аврах ангийн 28 албан хаагч зэрэг нийт 158 оюунлаг төрийн албан хаагчид “Бүтээлч уншлага” хийлээ. /2024.05.27/



Зураг 31: Шарын гол -Чанга уншлага

-Сургалт: "Номын баяр-2024"-ийн хүрээнд “Уран бичлэг” бийрэн бичлэгийн сургалтыг монгол хэл, уран зохиолын багш Т.Дэлгэрцэцэгтэй хамтран зохион байгуулж насанд хүрэгчид-11, хүүхэд-3 нийт 20 гаруй хүн хамрагдсан. /2024.05.23/



Зураг 32: Шарын гол - Бийрэн бичлэгийн сургалт

-Уралдаан, тэмцээн: "Номын баяр-2024"-ийн хүрээнд "Дүрийн тоглолт бүтээх" уралдааныг СӨББ болон ЕБС-ийн 56 сурагчдын дунд зохион байгуулж сумын 160 гаруй хүн үзэж сонирхлоо. /2024.05.18/



Зураг 33: Шарын гол - "Дүрийн тоглолт бүтээх" уралдаан

Цэцэрлэгийн нас: 1-р байр: 19-р цэцэрдлэг "Азар базар тазар-3"
2-р байр: 2-р цэцэрлэг "Долоон өндөгтэй доглон шаазгай"
3-р байр: 17-р цэцэрлэг "Долоон ишиг"
Тусгай байр: 14-р цэцэрлэг "Бээлий"

Сургуулийн нас: 7а /6-р сургууль/-"Хамгийн хөөрхөн охин"
5г /2-р сургууль/-"Эрэл" хүүхдийн жүжиг
3в /2-р сургууль/-"Норовын намтар"

Тусгай байранд: 6б /2-р сургууль/- "Замд таарсан бадарчин"

-Номын сангийн үйлчилгээ: Зөөврийн номын сангийн үйлчилгээгээр номын баярыг таниулж шинэ номын танилцуулга хийж сумын 148 иргэнд үйлчилсэн. /2024.05.20/



Зураг 34: Шарын гол - Зөөврийн номын сангийн үйлчилгээ

Тус сумын соёлын төвийн уриалгаар сумын ЕБС-ийн 14 сурагч номын санд ирж "Бүтээлч өдөр"-ийг зохион байгууллаа. Сурагчид номын баярыг тохиолдуулан сумын номын сангийн номоо сэргээн засварлах, урагдаж гэмтсэн номоо эмчилж нэг өдрийг номын сангийн ажилд тусалж өнгөрөөв. /2024.05.20/



Зураг 35: Шарын гол – Ном эмчлэх бүтээлч өдөр

Сумын соёлын төвийн номын санч ЕБС-ийн 9 сурагчидтай хамтран өөрт байгаа гар доорх материалаа ашиглан 16 ширхэг номын хавчуургыг номын баярын хүрээнд хийж урлалаа. /2024.05.22/



Зураг 36: Шарын гол – Номын хавчуурга

"Номын баяр-2024" -ийг тохиолдуулан сумын соёлын төвд 2024.05.18-05.27-ны өдрийг хүртэлх хугацаанд сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргалаа. Үзэсгэлэнд нийт 108 иргэд хүрэлцэн ирж үйлчлүүлсэн.



Зураг 37: Шарын гол – Номын үзэсгэлэн

ТАВ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН СОЁЛЫН ТӨВ

Орхон сумын Соёлын төв нь “Илүү их уншъя” уриан дор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулж тус сумын Соёлын төв сумын иргэд, уншигч, хүүхэд багачуудын дунд нийт 3 арга хэмжээг зохион байгуулж 110 хүнийг хамруулж ажиллалаа. Дархан суманд зохион байгуулсан хаврын номын баярын тус сумын ЕБС-ийн сурагчдын урлагийн тоглолт, бүтээлийн үзэсгэлэнгээр оролцсон. Үүнд:

1. Номын баярын нээлтийн үйл ажиллагаанд:

“Номын баяр-2024” нээлтийн үйл ажиллагаанд тус сумын ЕБ-ын 8 дугаар сургуулийн 7а, 10а ангийн сурагч, эцэг эхийн төлөөллүүд урлагийн тоглолт, бүтээлийн үзэсгэлэнгээр оролцсон. /2024.05.18/



Зураг 38: Орхон сумын уншигч хүүхдүүд номын баярын нээлтэд

2 Номын баярын үйл ажиллагааг сумын Соёлын төв 2024.05.18-24-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Үүнд:

-“Иогтой ном унших” : Дэлхийн номын өдөр, Хаврын номын баярыг угтан ном унших дадал хэвшлийг бий болгох, суралцагчдыг номд дурлуулах, номын сайн нөхөр болгох зорилгоор сумын ЕБ-ын 8 дугаар сургуулийн 1а ангийн 16 сурагчдыг “Иогтой ном унших” арга хэмжээнд хамрууллаа. /2024.05.23/



Зураг 39: Орхон сум- Иогтой ном унших хөтөлбөр

-“Уран жиргээ-2024” уран уншлагын уралдаан: Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, шүлэг, яруу найргийг уран тод уншуулах, тэдний авьяас билгийг хөгжүүлэх, нээн илрүүлэх зорилгоор сумын ЕБС, СӨББ-ын 84 хүүхдийн дунд "Уран жиргээ-2024" уран уншлагын уралдааныг зохион байгуулсан./2024.05.19/



Зураг 40: Орхон сум- Уран жиргээ уралдаан

ЗУРГАА. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН СОЁЛЫН ТӨВ

Хонгор сумын Соёлын төв нь “Илүү их уншъя” уриан дор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулж нийт 5 арга хэмжээг зохион байгуулж 158 хүнийг хамруулж ажиллалаа. Үүнд:

1. **Номын баярын нээлтийн үйл ажиллагаанд:** Тус сумын ЕБС-ийн 30 сурагч, эцэг эхийн төлөөллүүдтэй оролцож урлагийн тоглолт, дүрийн жагсаал, бүтээлийн үзэсгэлэнг толилуулав.



Зураг 41: Хонгор сумын уншигч хүүхдүүд номын баярын нээлтэд /2024.05.18/

2. **Номын баярын үйл ажиллагааг сумын Соёлын төв 2024.05.18-24-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Үүнд**

-Сургалт: Төв номын сангаас зохион байгуулсан үндэсний бичгийн “Түргэн уншлага”-ын уралдаанд тус сумын ЕБС-ийн 9а, 9б, 12а ангийн 24 сурагч амжилттай оролцсон.



Зураг 42: Хонгор сумын хүүхдүүд Түргэн уншлагын уралдаанд

-Уралдаан, тэмцээн: "Яруу найргийн хур" уран уншлагын уралдааныг XIV сургуулийн баг ангийн 53 сурагчдын дунд зохион байгуулсан. Мөн үеэр 58 боть номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргав. /2024.05.07/



Зураг 43: Хонгор сум – Уран уншлагын уралдаан

-Танин мэдэхүйн "Центавр" тэмцээнийг төсвийн байгууллага, аж ахуйн байгууллагуудын 18 хүний дунд зохион байгуулсан. /2024.05.24/




Зураг 44: Хонгор сум-Танин мэдэхүйн тэмцээн

-Үзэсгэлэн: Номын баярын хүрээнд сумын ЕБС-ийн 63 сурагчдын дунд "Бийрэн бичлэг"-ийн болон хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэн гаргалаа. /2024.05.17/




Зураг 45: Хонгор сум-үзэсгэлэн

Батлав
Номын сангийн захирал  Б.Цэцэгсүрэн

**"НОМЫН БАЯР ХАВАР-2024" АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН НЭГДСЭН ТӨСӨВ**

№	Зохион байгуулах арга хэмжээ	Хийх ажил	Тоо ширхэг	нэгж үнэ	Нийт үнэ	Байгууллагын төсөв	АЗДГ
1	Номын баярын нээлтийн үйл ажиллагаа/Номын кандидлаачдын өдөрлөг/	Урилга, гэрчилгээ хэвлэл	1	231,500	231,500	231,500	
		Зочлоод зориулсан хөнгөн цай, кофе, жижигхэн 50 хүнд	50	7,000	350,000	350,000	
2	"Игүү их уншъя" номын баярын үйл ажиллагаа /Гадаа зохион байгуулагдах ажил/	Хулдаасан хэвлэл /Б'В хэмжээтэй/	1	761,900	761,900	761,900	
		Хийлдэг бөмбөлөг болдох	500	240	120,000	120,000	
3	"Уншгачдын эвчин өдөр" Арга зөвлөлийн хүүхдээс	Хиланг өдрийн зочлоод өгөх 2 цэргийн хөдөлмөрийн хөгжтэй тэнцэх урамшуулал	4	15,600	62,400	62,400	
5	Эрдэм шинжилгээний хурал	Урилга хэвлүүлэх /эколог дэвтэрний нүүрэнд урилга хэвлэх/	60	10,000	600,000		600,000
		ЭШХ-д оролцогчдын хөнгөн цай, зууш болдох, нэг удаагийн аяга, цай кофе	50	10,670	533,500		533,500
		ЭШХ-д илтгэл тавьсан хүмүүсийн урамшуулал болдох	4	200,000	800,000		800,000
6	Дүрийн тоглолттой уншгачдын бага хурал	Оролцогч ангийн бэлэнд олгох урамшуулал	1	50,000	50,000		50,000
		Оролцогч ангийн хүүхдэд олгох дэвтэр	11	6,500	71,500		71,500
7	Гарын номын сан контент /10 дүгээр/	Гарын бэлэг болдох	10	19,800	198,000	198,000	
9	"Ангийн шилдэг номын сан" урагдсан контент хэлбэрээр	1-р байр	1	300,000	300,000		300,000
		2-р байр	1	200,000	200,000		200,000
		3-р байр	1	100,000	100,000		100,000
10	"Номтой зочин" контент	Урагдванд шаардлагатай ном авах	30	15,880	476,400	476,400	
11	"Ном" уран илтгэлийн урагдсан	1-р байр	2	100,000	200,000		200,000
		2-р байр	2	80,000	160,000		160,000
		3-р байр	2	60,000	120,000		120,000
		шүүгч	3	50,000	150,000		150,000
12	Нийт мөнгөн дүн	Хүүхдийн номын багц болдох	5	52,500	262,500		262,500
					5,747,700	2,200,200	3,547,500

Төсөв гаргасан: Арга зүйн  /С.Нэгрүү/

Зураг:46 Номын баярыг зохион байгуулахад зарцуулагдсан төсөв

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ХАРЬЯА НОМЫН САНГУУДЫН “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ,
НОМЫН ӨДРҮҮД-2024” БАЯРААР ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО,
ХАМРАГДСАН ХҮНИЙ НЭГДСЭН ТООН МЭДЭЭЛЭЛ

2024.05.31

Дархан-Уул аймаг

№	Байгууллагын нэр	Зохиосон арга хэмжээний тоо	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо
1	Төв номын сан	26	59	11,347
2	Хүүхдийн номын ордон	11	1	1,826
3	Шарын гол сумын соёлын төвийн номын сан	8	1	524
4	Хонгор сумын соёлын төвийн номын сан	5	1	158
5	Орхон сумын соёлын төвийн номын сан	3	1	110
Нийт		53	63	13,965

ХЯНАСАН:

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Б.Долгормаа

Б.ДОЛГОРМАА

4289366 1922050017 ГСТ7344

